

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2011 он ...сар..... өдөр

Улаанбаатар хот

ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН ЭРХ ЧӨЛӨӨНИЙ ТУХАЙ

Шинэчилсэн найруулга

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

Нийтлэг үндэслэл

1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

1.1. Энэ хуулийн зорилт нь Монгол Улсын Үндсэн хуульд заасан үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, үг хэлэх, хэвлэн нийтлэх эрх чөлөөг баталгаажуулахад оршино.

2 дугаар зүйл. Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хууль тогтоомж

2.1. Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, энэ хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2.2. Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

3 дугаар зүйл. Хуулийн нэр томьёо

3.1. Энэ хуульд заасан дараах нэр томьёог дор дурдсан утгаар ойлгоно:

3.1.1. “хэвлэл, мэдээллийн хэрэгсэл” гэж олон нийтэд редакторласан мэдээлэл тогтмол түгээдэг хэвлэл, радио, телевиз, цахим хуудсыг;

3.1.2. “хэвлэл мэдээллийн байгууллага” гэж мэдээлэл хайх, хүлээн авах, боловсруулах, редакторлан нийтлэх, түгээх үйл ажиллагаа эрхэлдэг хуулийн этгээдийг;

3.1.3. “сэтгүүлч” гэж гэж хөдөлмөрийн болон бусад гэрээний үндсэн дээр сэтгүүл зүйн үйл ажиллагаанд оролцож буй хувь хүнийг;

3.1.4. “сэтгүүл зүйн үйл ажиллагаа” гэж нийтийн хүртээл болгох зорилгоор мэдээлэл цуглуулах, боловсруулах, харилцаа холбооны бүх төрлийн сүлжээг ашиглан нийтлэх, нэвтрүүлэх, түгээх үйл ажиллагаа;

3.1.5. ”мэдээллийн нууц эх сурвалж” гэж мэдээлэл өгөгч, түүний нэр, хаяг,эрхэлж буй ажил, мэргэжил, гэр бүлийн байдал, уулзсан байр, хугацаа, захидал, төлбөрийн нэхэмжлэл болон мэдээлэл өгөгчийн хэн болохыг нь тогтооход шууд бусаар ашиглагдах бусад мэдээллийг;

3.1.6. “хэвлэл мэдээллийн байгууллагын редакц” гэж хэвлэл мэдээллийн байгууллагын олон нийтэд түгээх мэдээллийн бодлого, агуулгыг тодорхойлж буй этгээдийг;

ХОЁРДУГААР БҮЛЭГ

ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН ЧӨЛӨӨТ, ХАРААТ БУС БАЙДЛЫН БАТАЛГАА

4 дүгээр зүйл. Иргэдийн үзэл бодлоо илэрхийлэх, үг хэлэх, хэвлэн нийтлэх эрх чөлөөг хангах

4.1 Монгол улсад хүн бүр үндэс, угсаа, хэл,соёл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсрол, бэлгийн чиг

баримжаа, ял шийтгүүлсэн байдлыг үл харгалзан хараат бусаар үзэл бодлоо илэрхийлж хэвлэл, мэдээллийн хэрэгслээр түгээх, хэвлэл мэдээллийн хэрэгсэл байгуулах, эрхлэх эрхтэй.

4.2 Хуулийн хүрээнд мэдээ, мэдээллийг хайх, эрэн сурвалжлах, хүлээн авах, цуглуулах, дүн шинжилгээ хийх, өөрийн хэрэгцээнд ашиглах, эсхүл хэвлэн нийтлэх буюу бусад аргаар нийтэд түгээх замаар хэвлэл мэдээллийн эрх чөлөөг хэрэгжүүлнэ.

4.3 Хуулиар нууцад хамааруулснаас бусад тохиолдолд энэ хуулийн 4.2-т заасан мэдээ, мэдээллийн хүрээг хязгаарлахыг хориглоно.

4.4 Төрийн байгууллага, албан тушаалтан хүнийг хэвлэл мэдээллээр үзэл бодлоо илэрхийлсэнтэй нь холбогдуулан аливаа хэлбэрээр дарамт шахалт үзүүлэх, хариуцлага хүлээлгэхийг хориглоно.

4.4 Хууль бусаар мэдээлэл олж авснаас бусад тохиолдолд бусдад гэм хор учруулсан гэх үндэслэлээр эрүүгийн хариуцлага хүлээлгэхийг хориглоно.

5 дугаар зүйл. Хэвлэл мэдээллийн эрх чөлөөг төрөөс хангах

5.1 Үндсэн хууль болон энэ хуульд зааснаас бусад тохиолдолд хэвлэл мэдээллийн эрх чөлөөг хязгаарласан хууль тогтоомж батлахыг хориглоно.

5.2 Хуульд заасан үндэслэлээр шүүхийн шийдвэрээс бусад үндэслэлээр хэвлэл мэдээллийн хэрэгслийн үйл ажиллагааг зогсоох, хэвлэл мэдээллийн байгууллагыг татан буулгахыг хориглоно.

5.3 Хуульд заасан үндэслэл, журмаас гадуур төрийн байгууллага, албан тушаалтан хэвлэл мэдээллийн эрх чөлөөг хязгаарласан тушаал, шийдвэр гаргах буюу үйлдэл, эс үйлдэл хийхийг хориглоно.

5.4 Төрийн байгууллага, албан тушаалтан мэдээллийг түгээхийн өмнө хэвлэл мэдээллийн байгууллагад хяналт шалгалт хийх, агуулгыг цагдан хянах, мэдээлэл түгээхэд саад учруулах, мэдээлэл түгээсэнтэй нь холбогдуулан хэвлэл мэдээллийн байгууллагын үйл ажиллагаанд саад учруулах, зогсоох, аливаа хэлбэрээр хэвлэл мэдээллийн байгууллагын үйл ажиллагаанд хөндлөнгөөс оролцох, нөлөөлөхийг хориглоно.

5.5 Төрийн байгууллага, албан тушаалтан хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээлэл түгээсэнтэй холбогдуулан энэ хуульд зааснаас бусад хариуцлага хүлээлгэхийг хориглоно.

5.6 Төрөөс хэвлэл мэдээллийн хэрэгслийг хянах чиг үүрэгтэй байгууллага, албан тушаалтан бий болгох, санхүүжүүлэхийг хориглоно.

6 дугаар зүйл. Төрийн мэдлийн хэвлэл мэдээллийн хэрэгслийг хориглох

6.1 Төрийн байгууллага, нутгийн өөрөө удирдах байгууллага, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд өөрийн эзэмшилд хэвлэл, мэдээллийн хэрэгсэлтэй байхыг хориглоно. Зөвхөн хууль тогтоомж, эрх зүйн акт, лавлагаа, мэдээлэл нийтлэх зорилготой тогтмол хэвлэл, цахим хуудастай байж болно.

7 дугаар зүйл. Хэвлэл мэдээллийн байгууллагын үйл ажиллагааны хараат бус байдал

7.1 Хэвлэл мэдээллийн байгууллага нь хэвлэл мэдээллийн хэрэгслээр гаргах мэдээ, мэдээллийг хайх, хүлээн авах, шалгах, боловсруулах, эвлүүлэх, нийтлэх, нэвтрүүлэх, хадгалах, мэдээллийн эх сурвалжаа хамгаалах үйл ажиллагааг хуулийн хүрээнд хараат бус, чөлөөтэй эрхэлнэ.

7.2 Хэвлэл мэдээллийн байгууллага үйл ажиллагаагаа төрөөс хараат бус явуулна.

8 дугаар зүйл. Редакцийн бие даасан, хараат бус байдлыг хангах

8.1 Хэвлэл мэдээллийн байгууллагын редакц тухайн хэвлэл мэдээллийн байгууллагын үүсгэн байгуулагч, хөрөнгө оруулагч, хувь эзэмшигч нарын ашиг сонирхлоос хараат бусаар бие даасан үйл ажиллагаа явуулна.

8.2 Хэвлэл мэдээллийн байгууллагын үүсгэн байгуулагч, хөрөнгө оруулагч, хувь эзэмшигч редакцын үйл ажиллагаанд хөндлөнгөөс оролцох, нөлөөлөхийг хориглоно.

8.3 Хэвлэл мэдээллийн байгууллагын редакцын эрхлэгч нь үүсгэн байгуулагч эсхүл эзэмшигчтэй хараат бус байдлыг хангах гэрээ байгуулна.

8.4 Нийтлэл, нэвтрүүлгийн ивээн тэтгэгч, санхүүжүүлэгч тухайн нийтлэл, нэвтрүүлгийн агуулгад нөлөөлөхийг хориглоно.

ГУРАВДУГААР БҮЛЭГ

МЭДЭЭЛЛИЙН НУУЦ ЭХ СУРВАЛЖИЙГ ХАМГААЛАХ

7 дүгээр зүйл. Зохиогч, мэдээллийн эх сурвалжийн нууцлал

7.1 Хэвлэл мэдээллийн хэрэгслээр түгээх мэдээллийн зохиогч өөрийн нэрийг нууцлах, нууц нэр хэрэглэх, мэдээлэл өгсөн этгээд өөрийгөө нууцлах эрхтэй.

7.2 Хэвлэл мэдээллийн байгууллага болон түүний редакц, сэтгүүлч, бусад ажилтнууд мэдээлэл өгөгчийн хүсэлтээр мэдээллийн өгөгчийн хэн болохыг шууд ба шууд бусаар илчлэх мэдээллийг задруулахгүй байх үүрэг хүлээнэ.

7.3 Мэдээллийн нууц эх сурвалж зөвшөөрснөөс бусад тохиолдолд хэвлэл мэдээллийн хэрэгслийн редакц, сэтгүүлч, хэвлэн нийтлэх үйл ажиллагаанд оролцсон этгээдээс нийтлэл, нэвтрүүлгийн зохиогчоос мэдээллийн эх сурвалжаа илчлэх, мэдээлэл олж авсан арга, хэлбэрээ тайлбарлахыг шаардах, мэдээллийн эх сурвалжаа илчлэхээс татгалзсантай холбогдуулан аливаа хэлбэрээр дарамт, шахалт үзүүлэх, хариуцлага хүлээлгэхийг хориглоно.

8 дугаар зүйл. Сэтгүүлч нууц эх сурвалжаа илчлэх нөхцөл, журам

8.1. Сэтгүүлч эрүүгийн хэрэгт хохирогч, иргэний нэхэмжлэгч, хариуцагч, гэрч, шинжээч, хөндлөнгийн гэрчээр хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт, шүүхийн шатанд оролцох үедээ мэдээллийн эх сурвалжаа илчлэхээс татгалзах эрхтэй.

8.2. Сэтгүүлч зөвхөн дор дурдсан үндэслэлээр эрүүгийн хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын шатанд шүүгчийн захирамжаар мэдээллийн эх сурвалжаа илчилнэ.

8.2.1. тухайн мэдээллийн эх сурвалжийг өөр арга замаар мэдэх боломжгүй болох нь тогтоогдсон;

8.2.2. хүний амь нас, эрүүл мэндэд бодит халдлага учрахуйц гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үндэслэл байгаа бол.

8.3. Мөрдөн байцаагч, хэрэг бүртгэгч нь энэ хуулийн 8.2–д заасан үндэслэл байгаа гэж үзвэл шүүгчээр захирамж гаргуулах хүсэлт бичгээр гаргах бөгөөд уг хүсэлтэд дараахь баримтуудыг хавсарган прокурорт хянуулахаар хүргүүлнэ. Үүнд:

8.3.1. тухайн мэдээллийн эх сурвалжийг олж тогтоохоор хийсэн бүх ажиллагаануудтай холбогдох баримт бичиг;

8.3.2. бусдын амь нас, эрүүл мэндэд аюул учирч болзошгүй үндэслэл, нотолгоо.

8.4. Прокурор, шүүгч нь ирүүлсэн хүсэлтийг хянан үзэж энэ хуулийн 5.2-т заасан үндэслэлийн нотолгоо хангалттай бус гэж үзвэл нэмэлт мөрдөн байцаалтын ажиллагаа хийлгэхээр буцаана.

8.5. Энэ хуулийн 8.2–д заасны дагуу мэдүүлэг өгсний улмаас сэтгүүлч, мэдээлэл өгөгчийн амь нас, эрүүл мэндэд илт заналхийлэл учрахаар байгаа бол сэтгүүлчийн хүсэлтийг харгалзан мөрдөн байцаагч, хэрэг бүртгэгч тогтоол үйлдэн прокурорт танилцуулж, шүүгчээр батлуулсны үндсэн дээр цагдаагийн байгууллагын хамгаалалтад авна.

9 дугаар зүйл. Мэдээлэл өгөгчийг хамгаалах

9.1. Энэ хуулийн 8.2-т заасны дагуу сэтгүүлч мэдээллийн эх сурвалжийг илчилсэн нь хуульд өөрөөр

заагаагүй бол мэдээлэл өгөгчийг эрүүгийн хэрэгт оролцогчоор татах үндэслэл болгохыг хориглоно.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН БАЙГУУЛЛАГЫН ИЛ ТОД БАЙДАЛ, ХАРИУЦЛАГА

10 дугаар зүйл. Хэвлэл мэдээллийн байгууллагын ил тод байдал

10.1. Хэвлэл мэдээллийн хэрэгсэл өөрийн үүсгэн байгуулагч, хөрөнгө оруулагч, хувь эзэмшигчийн талаарх мэдээллийг жил бүр болон өөрчлөлт орсон тохиолдол бүрт хэвлэл мэдээллийн хэрэгслээр эсхүл өөрийн цахим хуудсаар олон нийтэд мэдээлнэ.

10.2. Хэвлэл мэдээллийн хэрэгслийн хувь эзэмшигчийн өмчлөлийн хувь хэмжээг хэвлэл мэдээллийн хэрэгслээр эсхүл өөрийн цахим хуудсаар олон нийтэд мэдээлнэ.

10.3 Хэвлэл мэдээллийн хэрэгсэл захиалагчаас нийтлэл, нэвтрүүлгийг төлбөртэй нийтлэн, түгээх бол “төлбөртэй” гэсэн тэмдэглэгээг заавал хийнэ.

11 дугаар зүйл. Хэвлэл, мэдээллийн байгууллагын хариуцлага

11.1. Хэвлэл мэдээллийн байгууллага, түүний редакц өөрийн түгээсэн мэдээллийн хариуцлагыг хүлээнэ.

11.2. Хэвлэл мэдээллийн хэрэгслээс бусад арга хэрэгсэлээр түгээсэн мэдээллийн хариуцлагыг зохиогч хүлээнэ.

12 дугаар зүйл. Хэвлэл мэдээллийн байгууллагын үйл ажиллагаанд хориглох зүйл

12.1. Хэвлэл мэдээллийн байгууллага нь төрийн эсрэг гэмт хэрэгт олон нийтийг уриалах, хүчирхийлэл, садар самууныг сурталчилах, оюуны өмчийн эрхийг зөрчих, хувь хүний хуулиар хамгаалсан нууцыг задруулах зэрэг үйл ажиллагаа явуулахыг хориглоно.

13 дугаар зүйл. Хэвлэл мэдээллийн байгууллагад гомдол гаргах

13.1 Хэвлэл мэдээллийн байгууллага өөрийн ёс зүйн дүрэм, хэм хэмжээг батлан үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллана.

13.2 Хэвлэл мэдээллийн байгууллага болон түүний сэтгүүлчдийн мэргэжлийн үйл ажиллагаанд гаргасан гомдол, маргааныг тухайн хэвлэл мэдээллийн байгууллага хүлээн авч, ёс зүйн дүрмийн дагуу хянан хэлэлцэнэ.

13.1 Хэвлэл мэдээллийн байгууллага нь гомдлыг үндэслэлтэй гэж үзвэл залруулга, уучлал нийтлэх болон бусад хэлбэрээр гомдол гаргагчийн гомдлыг барагдуулна.

14 дугаар зүйл. Хэвлэл мэдээллийн хариуцлагын өөрийн зохицуулалтын байгууллага

14.1 Хэвлэл мэдээллийн хэрэгслийн хараат бус, өөрийгөө зохицуулах тогтолцоог бүрдүүлэх зорилгоор Хэвлэл мэдээллийн зөвлөлтэй байна. /Цаашид зөвлөл гэнэ/

14.2 Зөвлөлийн бүрэлдэхүүн хэвлэл мэдээллийн байгууллагынүүсгэн байгуулагч, сэтгүүлч, олон нийтийн төлөөллөөс бүрдэнэ.

14.3 Зөвлөлийн гишүүдийг сонгохдоо төрөөс болон улс төрөөс хараат бус байдал, мэргэжил, ёс зүй, нэр хүндийн шалгуурыг харгалзан сонгоно.

14.4 Зөвлөлийн гишүүдийг сонгох үйл явц нь олон нийтэд нээлттэй, ил тод байна.

14.5 Зөвлөлийн үйл ажиллагааны хэлбэр нь гишүүдийн хурал байна.

14.6 Зөвлөл дүрэм, ажиллах журам, хурлын дэг, сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх журмыг Зөвлөлийн гишүүдийн хурлаар батлан, мөрдөнө.

15 дугаар зүйл. Хэвлэл мэдээллийн зөвлөлийн бүрэн эрх

15.2 Хэвлэл мэдээллийн байгууллага болон түүний редакц, сэтгүүлч нарын мэргэжлийн үйл ажиллагаанд гаргасан гомдол, маргааныг хүлээн авах, хянан хэлэлцэх, дүгнэлт гаргах, эвлэрүүлэх

15.3 Хэвлэл мэдээллийн байгууллагад залруулга, уучлал нийтлэх болон бусад хэлбэрээр гомдол гаргагчийн гомдлыг барагдуулах үүрэг хүлээлгэх

16 дүгээр зүйл. Хэвлэл мэдээллийн талаар гарсан гомдлыг шийдвэрлэх

16.1 Иргэн хэвлэл мэдээллийн байгууллага нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг гутаасан, худал мэдээлэл нийтлэгдсэн гэж үзвэл гомдлоо зөвлөлд гаргах эрхтэй.

16.2 Зөвлөл нэр бүхий хэвлэл мэдээллийн байгууллага иргэний нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг гутаасан талаарх гомдлыг 30 хоногийн дотор шалгаж шийдвэрлэнэ.

16.3 Иргэний алдар хүнд, ажил хэргийн нэр хүнд хэвлэлээр гутаагдсан гэж үзэж гомдол гаргасан этгээд тухайн алдар хүнд, ажил хэргийн нэр хүндэд хохирол учирсныг нотлох баримтыг гомдол хүлээн авагч байгууллагад гаргаж өгнө.

16.4 Энэ хуулийн 16.1-д заасан нь иргэн гомдлоо шийдвэрлүүлэхээр шүүхэд хандах эрхийг хязгаарлахгүй.

16.5 Зөвлөлийн гаргасан шийдвэрийг хүлээн зөвшөөрөхгүй бол гомдол гаргагч шүүхэд хандаж болно.

17 дугаар зүйл. Хэвлэл мэдээллийн зөвлөлийн санхүүжилт

7.1. Хэвлэл мэдээллийн Зөвлөлийн үйл ажиллагааг дараах эх үүсвэрээс санхүүжүүлнэ.

17.1.1. хэвлэл мэдээллийн байгууллага болон бусад иргэн, хуулийн этгээдийн хандив, тусламж;

17.1.2. олон улсын байгууллагын хандив, тусламж, санхүүжилт;

17.1.3. хуулиар хориглоогүй бусад эх үүсвэр.

17.2. Төрийн байгууллага, албан тушаалтан, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдээс Хэвлэл мэдээллийн Зөвлөлийн үйл ажиллагааны зардлыг санхүүжүүлэх буюу аливаа хэлбэрээр хандив, тусламж, санхүүжилт олгохыг хориглоно.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

ХУУЛЬ ТОГТООМЖ ЗӨРЧИГЧДӨД ХҮЛЭЭЛГЭХ ХАРИУЦЛАГА

18 дугаар зүйл. Хууль тогтоомж зөрчигчдөд хүлээлгэх хариуцлага

18.1. Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хууль тогтоомж зөрчсөн этгээдэд дараахь захиргааны хариуцлага хүлээлгэнэ.

18.1.1 Энэ хуулийн 4.4-д заасан төрийн байгууллага, албан тушаалтан хүнийг хэвлэл мэдээллээр үзэл бодлоо илэрхийлсэнтэй нь холбогдуулан аливаа хэлбэрээр дарамт шахалт үзүүлэх, хариуцлага хүлээлгэсэн бол зөрчил гаргасан албан тушаалтанд хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2-5 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх торгууль ногдуулах, ноцтой зөрчсөн эсхүл удаа дараа үйлдсэн бол албан тушаалаас халах үндэслэл болно.

18.1.2 Энэ хуулийн 5.2- д заасан хуульд зааснаас бусад үндэслэлээр хэвлэл мэдээллийн хэрэгслийн үйл ажиллагааг зогсоосон бол зөрчил гаргасан албан тушаалтанд хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2-5 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх торгууль ногдуулах, ноцтой зөрчсөн эсхүл удаа дараа үйлдсэн бол албан тушаалаас халах үндэслэл болно.

18.1.3 Энэ хуулийн 5.3-д заасан төрийн байгууллага, албан тушаалтан мэдээллийг түгээхийн өмнө хэвлэл мэдээллийн байгууллагад хяналт шалгалт хийх, агуулгад цензур, хяналт тавих, мэдээлэл түгээхэд саад учруулах, мэдээлэл түгээсэнтэй нь холбогдуулан хэвлэл мэдээллийн байгууллагын үйл ажиллагаанд саад учруулах, зогсоох, аливаа хэлбэрээр хэвлэл мэдээллийн байгууллагын үйл ажиллагаанд хөндлөнгөөс оролцсон бол зөрчил гаргасан албан тушаалтанд хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2-5 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх торгууль ногдуулах, ноцтой зөрчсөн эсхүл удаа дараа үйлдсэн бол албан тушаалаас халах үндэслэл болно.

18.1.4 Энэ хуулийн 5.6-д заасан төрөөс хэвлэл мэдээллийн хэрэгслийг хянах чиг үүрэгтэй байгууллага, албан тушаалтан бий болгох, санхүүжүүлсэн бол тухайн шийдвэрийг хүчингүй болгож, зөрчил гаргасан албан тушаалтанд хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2-5 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх торгууль ногдуулах, ноцтой зөрчсөн эсхүл удаа дараа үйлдсэн бол албан тушаалаас халах үндэслэл болно.

18.1.5 Энэ хуулийн 6.1-д заасан төрийн байгууллага, төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд өөрийн харьяанд хэвлэл, мэдээллийн хэрэгсэл байгуулвал татан буулгаж шийдвэр гаргасан зөрчил гаргасан албан тушаалтанд хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2-5 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх торгууль ногдуулах, ноцтой зөрчсөн эсхүл удаа дараа үйлдсэн бол албан тушаалаас халах үндэслэл болно.

18.1.6 Энэ хуулийн 10.5-д заасан хэвлэл мэдээллийн байгууллагын үүсгэн байгуулагч, хөрөнгө оруулагч, хувь эзэмшигчид редакцын үйл ажиллагаанд хөндлөнгөөс оролцсон бол зөрчил гаргасан иргэн, хуулийн этгээдийг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2-5 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх торгууль ногдуулах, ноцтой зөрчсөн эсхүл удаа дараа үйлдсэн бол албан тушаалаас халах үндэслэл болно.

18.1.7 Энэ хуулийн 10.6-д заасан нийтлэл, нэвтрүүлгийн ивээн тэтгэгч, санхүүжүүлэгч тухайн нийтлэл, нэвтрүүлгийн агуулгад нөлөөлсөн эсхүл нөлөөлөхийг оролдсон бол зөрчил гаргасан иргэн, хуулийн этгээдийг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2-5 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх торгууль ногдуулна.

18.1.8 Мэдээллийн эх сурвалжаа хуулинд заасан үндэслэлээс бусад тохиолдолд илчлэхийг шаардсан бол зөрчил гаргасан иргэн, хуулийн этгээдийг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2-5 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх торгууль ногдуулна.

18.1.9 Хэвлэл мэдээллийн хэрэгсэл өөрийн үүсгэн байгуулагч, хөрөнгө оруулагч, хувь эзэмшигчийн талаарх мэдээллийг жил бүр болон өөрчлөлт орсон тохиолдол бүрт олон нийтэд мэдээлээгүй бол зөрчил гаргасан хэвлэл мэдээллийн байгууллагыг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2-5 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх торгууль ногдуулах, ноцтой зөрчсөн эсхүл удаа дараа үйлдсэн бол татан буулгах үндэслэл болно.

19 дүгээр зүйл. Хууль хүчин төгөлдөр болох

19.1. Энэ хуулийг оны ... -р сарын-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА